



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

### Зочид буудал, дэн буудал, жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5. дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Ашид суврага ХХК-ний “Ашид эрдэнэ” зочид буудлын 17/013, Уранган ХХК-ний “Уранган” зочид буудлын 15/084, Гоулд констракшн ХХК-ний “Гоулд” зочид буудлын 14/014, Их цагаан даваа ХХК-ний “Цэнгүүн” зочид буудлын 13/139, Мөөлөн ХХК-ний “Ангара” зочид буудлын 17/174, Эм эс энд ти эс ХХК-ний “Эм эс энд ти эс” дэн буудлын 13/285, Адвейнтур Райдер ХХК-ний “Адвейнтур Райдер” дэн буудлын 16/112, Бишрэлт гүн ХХК-ний “Маргад” дэн буудлын 18/48, Агнай ХХК-ний “Эра” дэн буудлын 16/068, Истим ХХК-ний “Лонг лайф” дэн буудлын 16/142 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн,

1150500027

зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг  
Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА *Б.Батбаатар* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 02 сарын 09  
өдрийн 09 дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.02.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ашид суврага ХХК	5151406	Ашид эрдэнэ	БГД-ийн 14-р хороо 3-р хороолол Хасбаатарын гудамж 18/1
2	Уранган ХХК	2578166	Уранган	БГД-ийн 3-р хороо дунд голын хойд эрэг.
3	Гоулд конштракшн ХХК	2654822	Гоулд	БГД-ийн 2-р хороо ЭТӨЧ 65/1
4	Их цагаан даваа ХХК	5184619	Цэнгүүн	БЗД-ийн 18-р хороо Намянжүгийн гудамж 10/3
5	Мөөлөн ХХК	2860295	Ангара	БГД-ийн 3-р хороо Замчдын гудамж 80

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 02 сарын 09  
өдрийн А/03 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.02.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Адвейнтур Райдер ХХК	5654297	Адвейнтур Райдер	ЧД-ийн 3-р хороо Авзагын 18 байр
2	Тэнгисийн нүргээн ХХК	5385342	Гам	СБД-ийн 7-р хороо эрхүүгийн гудамж гам төв байр
3	Хэрлэн буян ХХК	2547163	Икс найт	БЗД-ийн 3-р хороо сансар үйлчилгээний төв
4	Бишрэлт гүн ХХК	2652749	Маргад	БГД-ийн 1-р хороо Шаравын гудамж 31а
5	Агнай ХХК	2113961	Эра	БЗД-ийн 1-р хороо ЭТӨЧ 20/5
6	Истим ХХК	6039081	Лонг лайф	БГД-ийн 8-р хороо 4-р хороолол 7-р байр 1-2

--ooOoo--